

НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН ИНЖЕНЕРИЙН АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Ажлын байрны зорилго, зорилт

Төслүүдийн хэрэгжилтийг хангах, саадгүй явуулахад дэмжлэг үзүүлж, төслүүдийн хүрээнд хийгдэх барилгын үйл ажиллагааг хариуцаж, гэрээний хэрэгжилтийг хангуулахад оршино.

Ажлын байрны зорилтууд

- 1.Төслүүдийн хүрээнд хийгдэх барилгын ажлыг хариуцах, хяналт тавих;
- 2.Захиалагч болон холбогдох оролцогч талуудад арга зүйн зөвлөгөө өгөх;
- 3.Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах.

Ажлын байранд баримтлах зарчим

- 1.Хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагааны зохицуулалт, нэгдсэн төлөвлөгөө, хэрэгжилт, тайлагналыг нэгжийн түвшинд бүрэн хангах;
- 2.Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн цар хүрээнд багтах нийт төслийн санхүү, худалдан авалт, тайлан мэдээ, хэрэгжилтийн уялдааг хангах;
- 3.Шинээр эхлэх төслүүдийн үйл ажиллагааг нэгдсэн нэгжийн бүтэц, зохион байгуулалттай уялдуулан хэрэгжүүлэх бодлогын хүрээг баримтлах.

Ажлын байранд хийж гүйцэтгэх ажил, үйлчилгээ

- 1.Техникийн болон инженер, техникийн нөхцөл, шаардлагыг бэлтгэх, үнэлэх, тендерийн баримт бичгийг бэлтгэх, гэрээний менежмент болон бусад холбогдох инженерийн ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг инженерийн нарийвчилсан зураг төсөл (ИНЗТ)-ийн зөвлөх үйлчилгээнд техникийн дэмжлэг үзүүлэх;
- 2.Барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх бүх бичиг баримт, зөвшөөрөл, бусад шаардлагатай шийдвэрийг техникийн хувьд алдаа мадаггүй, холбогдох техникийн код, стандартын шаардлагад нийцүүлэн ХББОСЯ, техникийн шинжээч болон бусад холбогдох байгууллага зэрэг холбогдох талуудтай зөвшилцөж байх;
- 3.Барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх техникийн нөхцөл, шаардлагыг бэлтгэх, үнэлэх, техникийн хяналт тавих, тендерийн баримт бичгийг бэлтгэх, үнэлэх, инженерийн бусад ажлуудад дэмжлэг үзүүлэх;
- 4.Бүтцийн тооцоо, дүн шинжилгээ хийх, үр ашиг, эдийн засгийн хэмнэлттэй барилга байгууламжийн зураг төсөл гаргах;
- 5.Барилга угсралтын захиалагчийн хяналт тавих ажилд сонгогдсон инженерүүдийн багийн үйл ажиллагааны нэгдсэн зохицуулалтыг хийх;

6.Барилгын талбай бүрд шаардлагатай бүх бичиг баримт, зөвшөөрлийг бүрдүүлэх, авах, батлах; төслийг гүйцэтгэх болон дуусгах явцад хяналт тавьж, шаардлагатай бүх зөвшөөрлийг авах; лиценз, зөвшөөрөл байгаа эсэхийг нягталж шаардлагатай тохиолдолд эргүүлэн татах, түдгэлзүүлэх; гэрээний хугацаа дууссан аливаа ажлыг зогсоож захиалагчид нэн даруй тайлагнах;

7.Барилгын ажлыг дуусгах ахисан болон эцсийн шатанд техникийн хорооны гишүүнээр ажиллах;

8.Шаардлагатай тохиолдолд төслийн талбайд удаан хугацаагаар ажиллаж төсөл хэрэгжүүлэх нэгжийн өмнөөс хяналт тавих;

9.ИНЗТ-ийн хүрээнд гаргасан зураг, тооцооны чанарын баталгааг шалгах;

10.Ажлыг цаг тухайд нь дуусгахын тулд барилгын зураг төслийн инженерүүдийн үйл ажиллагааг зохион байгуулах ;

11.ИНЗТ-ийн зөвлөх компаниас бэлтгэсэн бүх зургийг хянаж, зураг төсөл, техникийн нөхцөл, шаардлагатай бол ажлын тоо хэмжээг бэлтгэх , ажлыг хэрэгжүүлэх явцад тусалж, техникийн туслалцаа үзүүлэх;

12.Барилгын ажилд шаардагдах бүтцийн зураг төслийн танилцуулга, баримт бичиг, тайлан, материалын тодорхойлолтыг бэлтгэх ;

13.Зураг төсөл боловсруулах, барьж байгуулах, барилгын дараах үе шат бүрд барилгын бүх ажилд хяналт тавих;

14. Захиалагчаас өгсөн бусад үүргийг гүйцэтгэх.

Ажлын байранд тавигдах шаардлага

1. Иргэний инженерчлэл эсвэл холбогдох чиглэлээр бакалаврын зэрэгтэй байх
2. Усан хангамж, бохир ус, авто зам, эрчим хүчний хангамж болон бусад ижил төстэй салбарын барилгын зураг төсөл, гүйцэтгэл, эсвэл хяналтын чиглэлээр мэргэжлийн түвшинд дор хаяж 10 жилийн ажлын туршлагатай байх;
3. Төслийн удирдлага болон төрийн худалдан авах ажиллагааны АЗ гэрчилгээтэй байх;
4. Архитектур, иргэний барилгын инженерийн чиглэлээр инженерийн эрхийн гэрчилгээтэй байх;
5. Програм хангамж болон барилгын зураг төслийн програм ашиглах чадвартай байх;
6. Гадны санхүүжилттэй төслүүдэд ажиллаж байсан туршлагатай байх;
7. Англи болон Хятад хэлний мэдлэгтэй байх;
8. Нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, асуудлыг шийдвэрлэх ур чадвар, зөвлөмж боловсруулах чадвартай байх
9. Бие даан болон багаар ажиллах чадвартай байх;

Ажил горилогчид шаардагдах баримт бичиг

1. Англи хэл дээрх өргөдөл
2. Англи хэл дээрх анкет (АХБ-ны форматаар)
3. Төгссөн мэргэжлийн сургуулийн диплом, гэрчилгээний хуулбар
4. Өмнөх ажил олгогчийн 1-с доошгүй тодорхойлох захидал англи хэл дээр ирүүлэх